



Б.БЯМБАБААТАР

Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн
Аюулгүй байдлын
тэнхимийн ахлах
багш, хошууч

БАРИВЧЛАХ ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түүхийг эргэн судалбал: 11-13 дугаар зууны үеийн хууль цаазын сурвалж бичгүүдэд одоогийн хэрэглэж байгаагаас өөр утга, агуулгаар тусгалаа олжээ. Тухайлбал: “Их засаг хууль” (1186-120 он), “Юань гүрний Нэвтэрхий хууль” (13-16-р зуун), “Алтан хааны цааз” (1507-1582 он), “Монгол-Ойрадын их цааз”, “Халх журам хууль”, “Улаан хацарт” хэмээх баримт бичиг, Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг (1875-1918 он) зэрэг сурвалж бичгүүдэд шүүн таслах, тулган байцааж хэрэг хүлээлгэх зорилгоор зодох, занчих, эрүү шүүлтэнд оруулах зэргээр хэрэгжүүлдэг байжээ. Энэ нь шинж чанарын хувьд эрүүгийн байцаан шийтгэх албадлагын шинжийг бүрэн утгаар агуулж байсан боловч уг арга хэмжээ нь одоогийнх шиг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх агуулгыг бүрэн илэрхийлдэггүй байсан байна.

Дараа үеийн хууль цаазын бичгүүдэд дээрх ойлголт нь уламжилсан шинжтэй байдаг боловч ялтныг шөнийн цагаар байцаахыг хориглоно.. гэх мэт хүний эрхийг хамгаалах шинжтэй заалтуудаар баяжигдаж ирснээрээ онцлогтой байна. “Халх журам хууль”-д шахаа шургуулах, тангарагын эрүү, “Гадаад Монголын хууль зүйлийн бичиг”-т есөн эрүү зэрэг албадлагын арга хэмжээний төрлийг

заасан байх боловч эдгээр нь дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, байцаан шийтгэх ажиллагаанд саад учруулах, оргон зугтахыг таслан зогсоох зорилготой биш юм.

Харин “Халх журам” хуулийн 212 дугаар зүйлд: “хэн хүн хулгай хийвээс хааш хаашаа дөрөв дөрвөн алд өргөн газар гүн нүх ухааж жил дуустал хадъя”⁶⁵ гэж бичсэн нь хэдийгээр дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх агуулгатай мэт боловч голлох үүрэг нь хэрэгтнийг залхаан цээрлүүлэх, тарчлаах, хашраах, хэрэг хүлээлгэх зорилготой байсан нь харагдаж байна.

1924 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын анхдугаар их хурал, мөн онд хуралдсан Монгол ардын намын III их хурлаас хувьсгалт Монгол Улсын Хорих ял эдлүүлэх байгууллагын практик үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын үндсэн чиглэл зарчмыг тодорхойлж өгсөн байна. Монгол ардын намын III их хурлын тогтоолд : Гянданаа хоригдон бүхий хэрэгтэн ардыг үйлдвэрт сургах, сургаж гэгээрүүлэх, аливаа шүүхийн тогтоолгүйгээр хэнийг ч хорихгүй байх, гяндан хорооны байдал нэн муу байгааг даруй сайжруулах, насанд хүрээгүй хөвгүүд, охид хэрэгт холбогдох аваас гянданд хорихгүйгээр гэгээрүүлэх, аливаа хэрэгтэн ардын дотроос хүн төлөв, засрах байдалтайг нь гянданаа хорихгүйгээр үйлдвэр хийлгэвэл зохих... зэргийг онцлон заажээ.

Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх “Таслан сэргийлэх арга хэмжээ”-тэй салшгүй холбоотой ойлголт билээ. 1925 онд Монгол улсын 2-дугаар их хурлаас тогтоол гаргаж “Монгол улсын шүүхийн байгууламж, БНМАУ-ын аливаа шүүх таслах газруудыг байгуулах дүрэм”-ийг баталснаар одоогийн ЭБШ

⁶⁵Р.Оюунбадам, Д.Бадам. “Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт” УБ. 2005 он, 12 дахь тал.

хуулийн анхны үндэс болж, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ буюу сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэс, суурь тавигдах нөхцөл бүрджээ.

Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны анхны хуульчлагдсан үндэслэл нь 1931 онд батлагдсан “Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай” хуулийн гуравдугаар бүлгийн “Түр хорих байшингууд” гэсэн нэгдүгээр заалтанд тусгагдаж байжээ.

Үүний дараагаар 1966 онд батлагдсан БНМАУ-ын “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд заасан: “Урьдчилан хорих нөхцөл ба журам” гэсэн бүлэг байсан боловч энэ нь дараагийн хуулиудад тусгагдаагүй юм. Өөрөөр хэлбэл сэжигтэн, яллагдагчийг цагдан хорихтой холбогдсон хүний эрхийн хамгийн эмзэг ажиллагааг тусгайлсан хуулиар бус Эрүүгийн байцаан шийтгэх тухай үе үеийн хуулийн таслан сэргийлэх арга хэмжээний талаарх заалтууд, Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайд, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын даргын тушаал /нууцын зэрэглэлтэй гарч байсан/-аар батлагдсан заавар дүрмээр зохицуулагдаж иржээ. Энэ нь тухайн асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хэм хэмжээгээр бус ихэвчлэн Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх таслан сэргийлэх арга хэмжээний талаарх зохицуулалтаар хуульд тусгаж байсантай холбоотой юм.

Түүнчлэн уг ажиллагааны талаар гарсан Олон улсын гэрээ, НҮБ-ын жишиг дүрмүүд цөөнгүй байх бөгөөд эдгээр нь ихэвчлэн манай орны хууль тогтоомжид янз бүрийн хэмжээгээр тусгалаа олон хэрэгжиж байгаа ч эцсийн үр дүн хангалтгүй байгаа талаар хүний эрхийн байгууллагуудын зүгээс шүүмжлэлтэй тулгарсаар байна. Олон Улсын түвшинд хүний эрхийг хангах олон талт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын анхаарлын төвд ямагт байсаар ирсэн

энэхүү цагдан хорих онцгой төрлийн үйл ажиллагаа нь эрх зүйн шинжлэх ухааны судалгааны хүрээнд төдийлөн өртөөгүй, энэ сэдвээр хүний эрхийн байгууллагууд болон судлаачдын дундаас санал шүүмжлэл ихээхэн гардаг боловч одоог хүртэл томоохон судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй байгаа нь анхаарал татах асуудал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн түүхэн цаг хугацаанд Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тусгасан зүйл, заалт бүхий хуулиудыг холбогдох материалууд болон манай улсын зарим эрдэмтэд /С.Нарангэрэл, А.Лхагваа зэрэг/-ийн бичсэн ном зохиолуудаас судалж үзэхэд дараах байдлаар тусгагдаж ирсэн юм.

Тухайлбал:

Энэхүү “Монгол Ард Улсын дотор 1966 оны “БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль”⁶⁶-нд цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар тусгасан байдал.

/БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1966 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 50 дугаар зарлигаар батлагдсан/ тус хуулийн зорилтод: Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, нөхцөл журмыг зааснаас гадна. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль нь Урьдчилан мөрдөн байцаалтанд мөрдөгдөж байгаа этгээдийг хорих журам нөхцлийг тодорхойлно.., хэмээн зааж урьдчилан хорих нөхцөл журмын талаар тусгайлан, дэлгэрэнгүй байдлаар тусгасан байдгаараа өмнөх хуулиас ялгагдах чухал онцлогтой байдаг. Энэ хуульд сэжигтэн яллагдагчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар доорх байдлаар тусгагджээ.

⁶⁶А.Лхагва. “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж” УБ. 2013 он, 43 дахь тал

“БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль”-ийн “Урьдчилан хорих нөхцөл ба журам” гэсэн зургадугаар бүлгийн 38-р зүйлд зааснаар:

“Урьдчилан хорих үндэс нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуророос Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоосон журмын дагуу үйлдсэн тогтоол буюу шүүхийн магадлал болно. Насанд хүрээгүй яллагдагчийг урьдчилан хорихдоо Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтыг баримтлан гүйцэтгэнэ” гэж заасан байна. энэ хуульд заасан шаардлагыг зөрчсөн буруутай албан тушаалтан, хорих газрын даргад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.... гэж заасан нь нилээд шинэлэг агуулга бүхий хуулийн зохицуулалт болж өгсөн байна.

Энэ хуулийн 38 дугаар зүйлд зааснаар урьдчилан хоригдож байгаа этгээдэд шаардлагатай бол нэгжлэг хийж болно, урьдчилан хоригдож байгаа этгээдийг хорих байрандаа өөрөө өөртөө үйлчлэхээс өөр хөдөлмөрт дайчлахгүй, Хоригдож буй этгээдийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн зөвшөөрлөөр хорих газрын хяналтан дор, төрөл садантай нь уулзуулж, захидлаар харилцуулж болно. шаардлагатай гэж үзвэл дээрх журмаар эргэлт оруулж болно.

Урьдчилан сануулсаар байтал журам дэглэмийн шаардлагыг ноцтойгоор зөрчсөн этгээдийг прокурорын зөвшөөрөлтэйгөөр хорих газрын даргын тушаалаар торгуулын тусгаарлах байранд зургаа хүртэл хоногоор буюу зөвхөн шаардлагатай үед бугуйвч хэрэглэж болно... гэж нарийвчлан заасан байна. Тухайлбал: 40 дүгээр зүйл. Мөрдөнд урьдчилан хоригдож буй яллагдагчийг хорих журамд мөрдөгдөж буй яллагдагчыг нийтийн хорих байранд буюу прокурорын зөвшөөрөлтэйгөөр 1 хүний хорих байранд байлгана.

Эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдээс мөн насанд хүрээгүй хүмүүсийг насанд хүрэгсдээс, төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт яллагдагчийг бусад хэрэгт яллагдагсаас тусгаарлан хорино. Мөн хооронд нь харьцуулах шаардлагагүй яллагдагчийг тэдний хэргийг шууд эрхэлж буй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын заалт байвал тус тусад нь хорино.

Энэ хуулиар урьдчилан хорих нөхцөл журамыг нарийвчлан зааж үүний дотор хоригдогсдын байх өрөөний дулааныг +18 гэж тогтоосон, мөрдөгдөж буй этгээдийн эрх үүрэг, тэдгээрт оногдуулах сахилгын шийтгэлийн төрөл, хэрэгжүүлэх журмыг шууд заасан зэрэг хүний эрхэнд социалист хуулийн энэрэнгүй үзлээр хандсан, мөн урьдчилан хоригдож буй яллагдагч нь хорих газар тогтоосон журам дэглэмийг хатуу сахин биелүүлэх, захиргааны зааснаар хорих байр тасалгаандаа ээлжээр жижүүр хийх, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлэх, унтах босох цаг журамыг ягштал баримтлах, урьдчилан хорих газрын эд хогшилд гамтай хандах, урьдчилан хорих газрын ажилтантай зөв боловсон харьцах, тэдний шаардлагыг уг дуугүй биелүүлэх.

Мөн хуулийн 42 дугаар зүйлд хоол бусад хангамжийг тогтоосон нормоор хорих газраас хэрэглэж, хорих газраас зөвшөөрсөн бол ном унших түүнчлэн өргөдөл гомдлоо төрийн болон, олон нийтийн байгууллага, албан тушаалтанд урьдчилан хорх газрын захиргаагаар дамжуулан гаргах, хувийнхаа хувцсыг хэрэглэх, урьдчилан хорих газрын захиргаа нь өргөдөл гомдлыг 1 хоногоос хэтрүүлэхгүйгээр зохих хаягаар явуулах үүрэгтэй гэж заасан байна.

Эргэлт уулзалтын талаар мөрдөгдөж буй яллагдагчийг төрөл садан, хууль ёсны төлөөлөгчтэй нь уулзуулах явдлыг урьдчилан хорих газрын захиргаа, түүний хэргийг шууд эрхэлж буй мөрдөн байцаагч, шүүгч прокурор болон

шүүгчийн зөвшөөрөлтэйгөөр шийтгэгдээд таслан шийтгэх тогтоол нь хүчин төгөлдөр болоогүй этгээдийн хувьд уг хэргийг шийтгэсэн шүүгчийн дарга буюу шүүгчийн зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэнэ... гэжээ

Эдгээр зүйл заалтуудаас харахад тус хуульд хоригдогчийн эрх зүйн байдлын талаар цөөнгүй заалт оруулж өгөн урьдчилан хорих газрын дэглэм журам, хорих журам, мөрдөгдөж буй яллагдагчийн эрх, үүрэг, уулзалт авах журам, мөрдөгдөж буй яллагдагчийг хорих газраас чөлөөлөх үндэслэлүүд тусгайлан заасан байна.

Мөн хорих газраас чөлөөлөх болон суллах үндэслэлүүдийг дурьдахад:

Мөрдөгдөж буй яллагдагч нь урьдчилан хорих газраас дор дурьдсан үндсэн дээр чөлөөлөгдөнө. Үүнд:

А. Цагдан хорих арга хэмжээг хүчингүй болгосон

Б. Цагдан хорих арга хэмжээг таслан сэргийлэх өөр арга хэмжээгээр сольсон

В. Таслан шийдвэрлэх, цагаатгах тогтоол гарсан буюу хорихоос өөр ялаар шийтгэгдсэн.

Г. Хэргийг хэрэгсэхгүй болгосон буюу давж заалдах шатны шүүхээс хорих ялыг хорихоос өөр хөнгөн ялаар сольсон... зэрэг тохиолдлыг заасан бөгөөд чөлөөлөгдөх үндэс нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын тогтоол, шүүхийн магадлал буюу таслан шийдвэрлэх тогтоол болно... хэмээн нилээд нарийвчлан тусгаж өгсөн мөн түүнчлэн тус хуулийн 46 дугаар зүйлд нь “Урьдчилан хорих газруудын үйл ажиллагаанд хууль ёсыг нарийн чанд биелүүлж байгаа эсэхэд тавих хяналтыг Монгол Улсын прокурор болон түүний харьяа прокурорууд гүйцэтгэнэ... гэж тусгасан нь хүний эрхийг хүндэтгэх өнгө аясыг шингээсэн, урьдчилан хорих буюу цагдан хорих үйл ажиллагааг онцгойлон авч үзэж анхаарал хандуулсан байдлыг илэрхийлж байдаг.

Гэвч дараа дараагийн хууль тогтоомжуудад дээрх байдлаар тусгайлан ороогүй байгаа нь анхаарал татаж байна.

Хэдийгээр 1931, 1966 оны хуулиудад сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар тусгасан нь уг асуудлыг бүрэн шийдвэрлэх хэмжээнд хүрэхгүй боловч өмнөх хуулиудаас агуулгын болон зохицуулах зүйлийн хувьд харьцангуй өргөн хүрээтэй, яллагдагчийн эрх, үүрэг, яллагдагчтай уулзах, аюулаас хамгаалах арга, зэвсэг хэрэглэх, мөрдөгдөж буй яллагдагчийг хорих газраас чөлөөлөх үндэслэлүүд, прокурорын хяналт, хүний эрхийг хангахад чиглэгдсэн заалтууд дэлгэрэнгүй байдлаар тусгагдаж ирсэн байна.

Улсын Их Хурлаас 1999 оны 07 дугаар сарын 01-ны өдөр “Сэжигтэн яллагдагчыг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-ыг батлан гаргасан нь цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагааны талаар дагнасан анхны бие даасан хууль болсон юм.

Дээрх хуулийг батлан гаргасан нь цаг үеийн болоод нийгмийн шаардлага байсан бөгөөд уг хуульд нийцүүлэн гаргасан нилээд хэдэн дүрэм журмуудыг батлан мөрдөж байна.

2002 онд баталсан “Эрх зүйн шинэтгэл”-ийн арга хэмжээний хүрээнд цагдаагийн байгууллагын харьяаллаас гаран Нийслэлд цагдан хорих төв нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын, аймаг, сум дүүргийн цагдан хорих байр нь тухайн нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны харьяанд ажиллах болсон. Түүнчлэн цагдан хорих байр шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг аймаг нийслэлийн засаг дарга болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын саналыг үндэслэн Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн шийдвэрлэж байхаар болсон нь зарчмын